



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 105

Мандалговь

“Дундговь-Ус” ОНӨҮГазрын удирдах
зөвлөлийн дарга томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.3 а, ж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн 21.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: “Дундговь-Ус” орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын Удирдах зөвлөлийн даргаар С.Сүхбаатарыг томилсугай.

Хоёр: Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан дүрмийг мөрдөж ажиллахыг Удирдах зөвлөлд даалгасугай.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С. СҮХБААТАР

